

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ 2025 ОНД ХИЙЖ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Орхон аймаг

2025.06.05

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгж их хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	Авлигатай тэмцэх газраас болон нийгмийн даатгалын газраас бэлтгэн гаргасан контент, сурталчилгааны материалуудыг байгууллагын цахим хуудас, сошиал сувгууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдээллийн самбар болон бусад хэлбэрээр сурталчилж олон нийтэд хүргэнэ. Шударга ёс, хөгжил дэвшилд 110 мэдээллийн самбарыг тогтмол шинэчлэх /110 дугаарыг оруулан сурталчлах/	Жилийн турш	- тогтмол шинэчлэх, - тогтвортой байршуулсан байх - түгээсэн тоо - Давтамж - Хандалтын тоо	Иргэдийн авлигаас урьдчилан сэргийлэх мэдлэгийн нэмэгдүүлнэ .	Авлигатай тэмцэх газраас болон нийгмийн даатгалын газраас бэлтгэн гаргасан контент, сурталчилгааны материалуудыг байгууллагын цахим хуудас, сошиал сувгууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдээллийн самбар болон бусад хэлбэрээр сурталчилж олон нийтэд хүргэж ажилласан. Нийгмийн даатгалын газар нь Авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор албан байгууллагадаа “Авлигыг мэдээллэх санал хүсэлтийн хайрцаг болон Callpro үйлчилгээндээ авлига, ёс зүйтэй холбоотой санал гомдол” өгөх сувгийг байршуулан ажиллаж байна. Үүнтэй холбоотой иргэд, олон нийтэд цахим хуудсаараа дамжуулан 4 удаагийн постер мэдээлэл, авлига мэдээлэх сувгуудыг олон нийтэд сурталчлан таниулсан 1 удаагийн богино хэмжээний контент хийж хүргэсэн. Мөн Төрийн албан хаагчдыг ёс зүйтэй ажиллах талаар уриалсан 2 удаагийн рийл, контент хийж цахим хуудсандаа байршуулан түгээсэн. Тухайн постер, рийл нийт

						давхардсан тоогоор 8,352 хандалт авсан байна.
		Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Жилийн турш	- Оролцсон иргэдээс санал хүсэлт авч түүнд үндэслэн арга хэмжээ авсан байх - АТГ-аас өрнүүлж буй арга хэмжээтэй уялдсан байх	Иргэд олон нийтэд авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын талаарх мэдээлэл өгөх мэдлэгийг дээшлүүлнэ.	Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч ажилчдаас даатгуулагч иргэд хамгийн их асуудаг асуултыг жагсааж үзэхэд тэтгэвэр тогтоолгохоор ирсэн иргэд тухайн цаг хугацаанд тэтгэврээ хэдэн төгрөгөөр тогтоогдож байгааг мэдэх болон хурдан хугацаанд тэтгэврээ тогтоолгож авах хүсэлтэй байгаа нь жагсаалтаар гарч ирсэн. Иймд манай байгууллага процессын дахин инженерчлэл хийхээр судалгааны ажил явуулж байгаа бөгөөд 2025 онд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
		Авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн ёс зүй шударга байдлыг уриалсан 2-оос доошгүй видео контент бүтээж олон нийтэд уриалсан байх	2,3-р улиралд	- Авлига мэдээлэх 110 дугаарыг сурталчилсан байх - Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудас болон нийгмийн сүлжээ, самбар зэрэг бүхий хэлбэрээр	Авлигын хор хөнөөл, хэлбэр, авлигаас ангид байх үзлийг төлөвшүүлнэ.	Тус газрын Авлигын эсрэг стандартын комисс болон Ёс зүйн дэд хорооноос “Ёс зүйгээрээ манлайлъя” сарын аяныг зохион байгуулж хэлтэс нэгжүүдийн хооронд болзолт уралдаан зохион байгуулж ажилласан бөгөөд 06 сарын 10-ны өдөр уралдааныг дүгнэж ёс зүй, харилцаа хандлага, шударга байдлаараа хамт олноо манлайлсан шилдэг ажилтан болон шилдэг тасаг нэгжийг шалгаруулахаар товлонд байна. Мөн Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийг албан хаагчдад таниулах зорилгоор АХА тэмцээн зохион байгуулж тус тэмцээнд Тэтгэврийн тогтоол олголтын байцаагч Б.Эрдэнчимэг түрүүлсэн.

				хүргэсэн байх		Мөн аяны хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүй шударга байдлыг уриалсан Захиргаа хяналтын хэлтсийн албан хаагчийн өөрсдийн тоглосон 1 видео контент хийж олон нийтэд хүргэж ажилласан бөгөөд дээрх контентийг 420 хүн үзэж 112 лайк дарж 56 шэйр хийсэн байна. Төлөвлөгөөний дагуу III дугаар улиралд хоёр дахь контентийг бэлтгэн хүргэхээр “Тусгал ТВ”-тэй гэрээ байгуулан ажиллаж байна.
		Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор авлигын талаар мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр ач холбогдлын талаар сурталчлах	Жилийн турш	Сурталчилга аг бүх арга хэлбэрээр, мэдээллийн сувгаар хүргэсэн байх	Авлигын мэдээлэл өгөх Шүгэл үлээх идэвхийг нэмэгдүүлнэ .	Тус газрын Авлигын эсрэг комиссын санаачлагаар Авлигын талаарх мэдээлэл өгөх сувгуудыг иргэд даатгуулагч, олон нийтэд сурталчлах зорилгоор байгууллагын 75776699 утсаар, мөн санал хүлээн авах хайрцагаар, байгууллагын вэб хуудсаар дамжуулан шүлэг үлээх боломжтой талаар богино хэмжээний видео бичлэг хийж олон нийтийн сүлжээнд байршуулсан. Мөн тус газрын Авлигын стандартын мэдээллийн самбарыг нэг давхарт байрлуулж олон нийт авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх мэдээллийг нээлттэй авах боломжийг бүрдүүлсэн.
		Төрийн албанд шинээр томилогдсон болон бусад албан хаагчдад зориулсан авлигын эсрэг сургалтын зохион байгуулах	3-дугаар улирал	- Шинээр томилогдсон албан хаагчдыг сургалтад бүрэн хамруулсан байна.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг талаарх мэддэг.	2025.06.03-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газар АТТ газартай хамтран зохион байгуулсан Авлигын эсрэг цахим сургалтад 2025 онд шинээр томилогдсон Төрийн захиргааны болон үйлчилгээний 9 албан хаагч, Нийгмийн даатгалын 1 төлөөлөгч тус тус хамрагдсан.

						(Шинээр томилогдож сургалтад хамрагдсан албан хаагчид:Тэтгэмжийн тогтоолт олголтын байцаагч Ж.Баяржаргал, Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн Т.Даваажаргал, Үйл ажиллагааны нягтлан бодогч З.Золбаатар, Цахим үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн С.Жавзмаа, Тэтгэмжийн тогтоолт олголтын байцаагч Д.Лхагвадулам, Сайн дурын даатгалын байцаагч Л.Мөнхтуяа, Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн Б.Раяа, Нэг цэгийн үйлчилгээний байцаагч мэргэжилтэн Н.Сайхантуяа, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Д.Хонгорзул, төлөөлөгч Т.Энхцэцэг)
		Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийг танилцуулах, Авилга ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	4 дүгээр улирал д	- ЭММ-ийн эмч мэргэжилтнүүдэд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна.	ЭММ-ийн эмч мэргэжилтэнүүд Авлига ашиг сонирхолын зөрчилгүй ажилласан байна.	Монгол улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм батлагдсан ба үүнтэй холбоотойгоор эрүүл мэндийн магадлалын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны жагсаалт шинэчлэгдэн гарсан.Энэ бүхний талаар 9 Өрхийн эрүүл мэндийн төв болон Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн амбулаторийн эмч нарт 1 удаа, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/177, А/433 тоот тушаалаар батлагдсан даатгуулагч иргэний эмнэлгийн хуудас олгох журмын талаар 9 Өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, 12 хувийн хэвшлийн эмнэлэг, Эрдэнэт-медикал эмнэлэг,

						Эрдэнэт-сувилал, Жаргалант сумын эрүүл мэндийн төв зэрэг газруудад нийт 3 удаагийн сургалт зохион байгуулсан байна.
2.	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг сайжруулах	“Төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	3-дугаар улирал	- Журамд заасны дагуу НД-ын байгууллагын 1-ээс доошгүй үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх - Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх тайлагнах	Шийдвэр гаргах түвшинд олон нийтийн оролцоог хангаж хэвшинэ.	Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл нийт 9 гишүүн, 1 нарийн бичигтэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд иргэнийг төлөөлсөн нэг гишүүн ажиллуулж байна. Байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг сайжруулах зорилгоор иргэдээс үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 оны хагас жилийн байдлаар сэтгэл ханамжийн судалгаанд 354 иргэд хамрагдсан. Судалгаанд оролцсон иргэд ёс зүй харьцаа хандлага, үйлчилгээг үнэлэхдээ маш сайн үнэлгээг 336 иргэн, Байгууллагын мэдээлэл ил тод байдлыг үнэлэхэд 232 иргэн ил тод байдаг гэж үнэлсэн байна.
		Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.	Жилийн турш	- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагаа	Авлигын эрсдэлийг бууруулна.	2025 онд шинээр тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан 573, ажилгүйдлийн тэтгэмж авах 292 даатгуулагч иргэний үйлчилгээ авахаар хүсэлт гаргасан өргөдлийн маягт бүрт авлига, ашиг сонирголоос ангид байх, авлигын шинжтэй үйлдлийг мэдээллэх утасны дугаар бүхий анхааруулга байршуулсан нь нийгмийн нөлөөлөл, иргэдийн оролцоог хангахад дөхөм болж байна.

				г нэмэгдүүл эх чиглэлээр арга хэмжээ авсан байна.		Мөн утсаар болон нууц хайрцаг, сэтгэл ханамжийн судалгаа, өргөдлийн маягт зэргээр дамжуулан авлигын шинж чанартай үйлдлийн мэдээллийг иргэдээс авах боломж, сувгийг үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж байна.
		Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих	2,4 дүгээр улирал д	- Хуульд заасан нээлттэй мэдээллүүдийг бүрэн байршуулж, шинэчилсэн байх - Хариуцах албан тушаалтыг томилсон байх	Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ сайжирна.	Тус газар нь байгууллагын 48 мэдээллийг вэб хуудас, пэйсбүүк хаяг, мэдээллийн 6 самбарт байршуулж, хэрэгжилтийг шалгах эрх бүхий байгууллагын эхний улирлын үнэлгээгээр 96.43% үнэлүүлсэн.
		Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад гарсан аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авлига ашиг сонирхолын талаарх мэдээллийг холбогдох байгууллага албан тушаалтанд мэдээллэх	Жилийн турш	- Мэдээллийн тоо	Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад аливаа хууль бус үйлдэл, зөрчилгүй гараагүй байна. Гарах шалтгаан	Тус газрын Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3 дугаар зорилтын 5 дугаар арга хэмжээнд “Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад гарсан аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авлига ашиг сонирхолын талаарх мэдээллийг холбогдох байгууллага албан тушаалтанд мэдээллэх” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах арга хэмжээ болгон оруулж өгсөн. 2025 оны хагас жилийн байдлаар Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад

					нөхцөл буурсан байна.	аливаа хууль бус үйлдэл, зөрчилгүй гараагүй байна. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд иргэдийн хүсэлтийг үндэслэн 300 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон байдалд ЭММТөв Зөвлөлөөс дахин магадлал хийж, 2025 оны 04 дүгээр сард нийт иргэдээс Орхон аймгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэжээг мөрдөж буй байдал, авлига ашиг сохирхолын зөрчил гаргаж буй эсэхэд үнэлгээ өгөх зорилгоор судалгаа авч үр дүнг ЭММТөв зөвлөлд тайлангаж ажилласан.
		Нийгмийн даатгалын байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага хооронд болон ажилтан албан хаагчидтай байгуулж буй аливаа гэрээ хэлэлцээр авлига ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх талаар зохицуулалт тусгах	Жилийн турш	Байгуулсан гэрээ хэлэлцээрийн тоо Үр дүн	Гэрээ хэлэлцээр байгуулагч талууд авлига ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлнэ.	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа албан хаагчдын гэрээний 3.2.9 дэх хэсэгт Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт, 7 дугаар зүйлийг хэрэгжүүлэн ажиллах. Албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа авлига, ашиг сонирхолын зөрчил, гэмт хэргийн шинжтэй ямар нэгэн үйлдэл гарсан тохиолдолд Авлигатай тэмцэх газрын 110 утсанд мэдэгдэх буюу https://orhon.ndaatgal.mn/ хандаж мэдээллэх талаар зохицуулалт тусган ажиллаж байна.
		Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, Ёс зүйн дэд хороо, ЭММЗ-д ирсэн өргөдөл гомдол		Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо,	Маргаан шийдвэрлэх хугацаа, өргөдөл	Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл нь 9 гишүүн, 1 нарийн бичгийн даргаас бүрдсэн бүрэлдэхүүнтэйгээр эхний хагас жилийн байдлаар нийт 12

		мэдээлэл, маргаан таслах үйл ажиллагааг сайжруулах, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх	Жилийн турш	Шийдвэрлэсэн хугацаа	хүсэлтийг шийдвэрлэх хугацаа буурсан байна.	өргөдөл ирснийг сар бүр 1 удаа хуралдаж хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. 2025 оны эхний хагас жилд Эрүүл мэндийн магадлалын зөвлөл 21 удаа хуралдаж 1501 иргэн /даатгуулагч/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны асуудлыг шийдвэрлэв. ЭММЗ-ийн хурал бүрд видео-камер ажиллуулж бичлэг хийдэг ба хурлын дараа бичлэг болон хурлын файлаа Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлрүү илгээдэг. Энэ нь хурлын үйл явцыг төв зөвлөл бүрэн хянах, мөн хурлын дараа гомдол, санал гарахад эргэж тухайн асуудлыг шүүж үзэх зэрэгт ач холбогдолтой байна. 2025 оны эхний хагас жил Ёс зүйн дэд хороонд 1 өргөдөл ирсэн бөгөөд ёс зүйн дэд хорооны дүгнэлтээр ёс зүйн зөрчил биш гэж дүгнэгдсэн.
3.	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авах	Цахимаар үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, иргэд олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх	Жилийн турш	- Цахим үйлчилгээний тоог нэмэгдүүлэх - Цахим үйлчилгээний талаар иргэд олон нийтээс санал асуулга судалгаа авах	Төрийн байгууллагын чанар хүртээмж дээшилнэ.	Авлига, ашиг сонирхлын зөрчил нийгмийн даатгалыг газрын хэмжээнд үүсээгүй бөгөөд урьдчилан сэргийлэх зорилгоор цахимаар үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, иргэд олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх үүднээс үйлчилгээний заалаар үйлчилгээ авахаар ирсэн иргэдэд Орхон аймгийн нийгмийн даатгалын байгууллагын фэйж хуудасыг дагахыг зөвлөж мөн portal.ndaatgal.mn сайтаар хэрхэн эмнэлгийн хуудсаа баталгаажуулж хүсэлт илгээх, сайн дурын даатгалын гэрээ хэрхэн шинээр байгуулах,

				- Дүн шинжилгээ хийж арга хэмжээ авах		сунгалт хийх, төлбөрөөр яаж төлөх талаар нийт 1289 иргэнд зөвлөн тусалж ажилласан. Нийгмийн даатгалын газрын иргэдэд үзүүлж байгаа 43 төрлийн үйлчилгээнээс 17 үйлчилгээ бүрэн цахимжсан байна.
		“Товш” аппликэйшнийг сурталчлах, санал өгөх ажлын зохион байгуулах	2.3-дугаар улирал д	“Товш” аппликэйшн ийг сурталчлах, санал өгөх ажлын зохион байгуулах - Хандсан мэдээлэл авсан иргэдийн тоо	Иргэдийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлнэ .	“Товш” аппликэйшний талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор постер мэдээлэл бэлтгэн цахим хуудсаараа дамжуулан хүргэсэн. Хандсан мэдээлэл авсан иргэдийн тоо-1398 Таалагдсан-45 Хуваалцсан-15
		Нийтийн албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авах, Шинээр томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянуулсаны дараа томилох	Жилийн турш	- ХАС ХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлсэн байх - ХАСУМ хянуулсны дараа томилж хэвшсэн байх	Төрийн албан хаагчийн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдаж, төрийн албанд итгэх иргэдийн	2025 оны 02 дугаар сард Төрийн захиргааны 19 албан хаагч ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргаж тайланг холбогдох газар хүргүүлэн ажилласан. Хагас жилийн байдлаар ТЗ-7 ангилал зэрэглэлд шинээр томилогдож ХАСУМ хянуулсан албан тушаалтан гараагүй байна.

					итгэл сайжирна.	
		Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн дүрэм, журмын төсөлд санал өгөх	Жилийн турш	- Санын тоо	Эрх зүйн орчин сайжирсан байна.	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын А/199-р журмын нэмэлт өөрчлөлт, мөн RPA болон SICOS системийг хөгжүүлэлтэд нийт 3 удаагийн 10 заалт бүхий саналыг хүргүүлэн ажилласан.
		Тухайн жилд Нийгмийн даатгалын байгууллагаас авлига ашиг сонирхолын зөрчил үүссэн тухай эрх бүхий байгууллагаас шаардлага хүргүүлсэн, ашиг сонирхолын зөрчил үүссэн байж болзошгүй тохиолдолд зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Тухай бүр	- Зөрчил илэрсэн тохиолдол хуульд заасан арга хэмжээ авсан байх - Авсан арга хэмжээний үр дүн	Ашиг сонирхолын зөрчил үүссэн нөхцөлд арга хэмжээ авч тайлагнаж ажилласан байна. Байгууллагын дотоод шударга байдал сайжирна.	Авлига сонирхолын зөрчил үүссэн тухай эрх бүхий байгууллагаас шаардлага хүргүүлсэн болон ашиг сонирхолын зөрчил үүссэн байж болзошгүй тохиолдолд бүртгэгдээгүй.
		Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах	Жилийн турш	- Шударга байдлын үнэлгээний хувь	Шударга байдлын үнэлгээг 90%-с дээш үнэлүүлсэн байна.	2024 оны ДШБҮ-ээр төрийн 16 яамнаас 2023 оны үзүүлэлтээс ХНХЯ (11.2) өсөж 79,3 үнэлэгдэж эхний 5-д эрэмбэлэгдсэн. 2024 оны ШБҮ-нд төрийн 34 агентлаг хамрагдснаас НДЕГ 2023 оны 69,5 -аас өсөж 74,5 үнэлэгдэж эхний 18-д эрэмбэлэгдсэн. НДЕГ-аас баталсан “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг удирдлага болгон өөрийн байгууллагын авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажилтан

						албан хаагчдын авилга албан тушаалын гэмт хэрэгт өртөх эрсдэлт нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж 2025 оны эхний хагас жилийн байдлаар авлига ашиг сонирхолын зөрчилтэй холбоотой иргэнээс гомдол санал хүсэлт гараагүй, зөрчилтэй үйлдэл үүсээгүй байна.
		Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал шийдвэр, журам дүрэм, авлига ашиг сонирхлын зөрчил гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл хүчингүй болгуулах санал хүргүүлэх, өөрчлөлт оруулах хүчингүй болгох	Тухай бүр	- Хүчингүй болгуулах аар гаргасан саналын тоо - Авлига ашиг сонирхолын зөрчил гарах нөхцөл үүсч болзошгүй тушаал шийдвэр, зөвлөмжийн тоо	Авилга ашиг сонирхолын зөрчил гарах нөхцөл боломж бүрдүүлсэн тушаал, шийдвэр, зөвлөмж, дүрэм, журам гаргахгүй ажилласан байна.	Тус газар 2020 оноос бэлтгэл ажил хангаж, 2023 онд олон улсын Авлигын эсрэг менежментийн тогтолцоо ISO37001:2016 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн нь Монгол улсад анх удаа авлигын эсрэг стандарт нэвтрүүлсэн төрийн байгууллага болсон. Стандартын дагуу байгууллага албан тушаалтны тушаал шийдвэр, журам, заавруудыг гаргаж стандартыг мөрдөн ажиллаж байна. 2025 оны хагас жилд Авилга ашиг сонирхолын зөрчил гарах нөхцөл боломж бүрдүүлсэн тушаал, шийдвэр, зөвлөмж, дүрэм, журам гаргахгүй ажилласан.

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР